



**Оюу толгой ХХК**

Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны  
удирдлагын тогтолцооны журам

Техникийн нөхөн сэргээлт хийх журам

Техникийн нөхөн сэргээлт хийх журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0002-М	Хувилбар: 1.1

## 1 ЗОРИЛГО

Уг журмын зорилго нь барилгын талбай, түр зуурын авто зам, зам, карьерт техникийн нөхөн сэргээх үе шат, мөрдөх ёстой шаардлагуудын талаар удирдамж өгөхөд оршино. Мөн энэхүү журам нь цооногийг хаах, таглах, тэгшлэх, тэмдэглэл хийхтэй холбоотой Оюу Толгойн (ОТ) ЭМААБО-ны бодлого, журмын хэрэгжилтийг хангана.

## 2 ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү журам “Оюу толгой” компанийн “Газар хөндөхөд тавих хяналт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө”-ний (ОТ-10-Е14-PLN-0001) салшгүй бүрэлдэхүүн хэсэг учраас “Уурхайг хаах төлөвлөгөө”-нд (ОТ-10-Е14-PLN-0002) тусгасан ил уурхай, суултын бүс, эрдэсийн хаягдлын цэг гэх мэт уурхайн тодорхой байгууламжуудаас бусад хөндөгдсөн талбайн техникийн нөхөн сэргээлтэд мөрдөнө.

Өөрөөр хэлбэл энэ журам хайгуул, барилга угсралт, бүтээн байгуулалт, малталт болон уул уурхайн үйл ажиллагааны явцад эвдэрсэн газарт хамааралтай юм.

## 3 АЛБАН ТУШААЛ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Ажил үүрэг	Хариуцлага
<b>Төслийн удирдлагын баг болон Үйл ажиллагааны хороо</b>	<ul style="list-style-type: none"> <li>Ашиглагдаагүй авто зам, замыг тодорхойлон, нөхөн сэргээлтийн ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгох.</li> <li>ОТ-н үйл ажиллагаатай холбоотой аажмаар нөхөн сэргээлт хийж болох эвдэрсэн газруудыг тодорхойлж, тэдгээр талбайн нөхөн сэргээлтийн журмыг санаачлан боловсруулах.</li> <li>Тухайн газар нутагт техникийн нөхөн сэргээлт хийхэд зарцуулахаар тооцоолсон зардлыг бизнесийн жилийн төсөвт суулгаж, батлуулах.</li> </ul>
<b>Газар шорооны ажлын хэлтэс</b> <b>Төслийг зохицуулагч баг</b>	<ul style="list-style-type: none"> <li>Зам, түр зам, карьер болон цооногийг нөхөн сэргээхдээ энэхүү журмыг дагаж мөрдөх.</li> <li>Нутгийн малчид, ард иргэд, мал сүрэг гэмтэж бэртэх болон цооногийг таглах ажлыг зохих журмын дагуу гүйцэтгэхгүй, цооногийг таглахгүй үлдээсний улмаас осол гарах эрсдэлийг бууруулах үүднээс цооногийн нөхөн сэргээлтийн журмыг дагаж мөрдөх.</li> <li>Төлөвлөсөн талбайд техникийн нөхөн сэргээлт эхэлсэн, дууссан талаар Газар хариуцсан байгаль орчны ажилтанд мэдэгдэх.</li> <li>Техникийн нөхөн сэргээлтийг амжилттай хийсэн газруудад тэмдэг тавих.</li> </ul>
<b>Байгаль орчин, биологийн олон янз байдал хариуцсан менежер</b>	<ul style="list-style-type: none"> <li>Техникийн нөхөн сэргээлтийн хэрэгжилтийн талаар холбогдох хэлтсүүдийн удирдлагатай хэлэлцэхэд нь Байгаль орчны багуудад тусалж дэмжих.</li> </ul>
<b>Газар хариуцсан байгаль орчны ажилтан</b>	<ul style="list-style-type: none"> <li>Зам болон түр замыг нөхөн сэргээхдээ самнах шаардлагатай эсэхийг тодорхойлох, нөхөн сэргээсэн зам, түр замын талбайд нөхөн сэргээлт амжилттай хийгдсэн эсэхийг хянах.</li> </ul>

Хуудас 2-16

ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ПРОСПЕКТ ЦАХИМ

ХУУДАСНААС ХАРНА УУ!

ХЭВЛЭСЭН ОГНОО: 2016-12-21

Техникийн нөхөн сэргээлт хийх журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0002-М	Хувилбар: 1.1

	<ul style="list-style-type: none"> <li>Карьерын нөхөн сэргээлтийг зохих журмын дагуу хийсэн эсэхийг шалгаж, нөхөн сэргээлт амжилттай хийсэн эсэхийг тогтоох зорилгоор нөхөн сэргээлт хийгдсэн талбайд нөхөн сэргээлтийн хяналт-шинжилгээ явуулах.</li> <li>Тухайн газрыг Рио Тинтогийн “Е14: Газар хөндөхөд хяналт тавьж, нөхөн сэргээх” стандартын стандартын дагуу нөхөн сэргээлгэх.</li> <li>Төслийг уялдуулан зохицуулах багууд техникийн нөхөн сэргээлтийг зохион байгуулаагүй талбайд тэмдэг тавих.</li> </ul>
<b>Газар зүйн мэдээллийн системийн ажилтан</b>	<ul style="list-style-type: none"> <li>Техникийн нөхөн сэргээлтийн үр дүнг тусгасан гео мэдээллийн сан ажиллуулна.</li> </ul>
<b>Ургамлын судалгааны баг</b>	<ul style="list-style-type: none"> <li>Техникийн нөхөн сэргээлтийн үзлэг шалгалтад оролцож, биологийн нөхөн сэргээлт хийх шаардлагатай нөхцөл бүрдсэн эсэхийг тодорхой тайлбар өгөн бататгах.</li> </ul>
<b>ЭМААБО-ы хууль дүрмийн хэрэгжилт хариуцсан баг</b>	<ul style="list-style-type: none"> <li>Уурхайн цогцолбороос гаднах нөхөн сэргээсэн газрыг орон нутгийн засаг захиргаанд холбогдох хуулийн шаардлагын дагуу буцаан өгөхийн өмнөх улсын <i>комиссын</i> шалгалтыг зохион байгуулах.</li> </ul>
<b>Өрөмдлөгийн ахлах зохицуулагч</b>	<ul style="list-style-type: none"> <li>Бүх цооног болон өрөмдлөгийн талбайн хучилт, нөхөн сэргээлт, хяналтыг энэхүү журмын дагуу хийлгэх.</li> <li>Өрөмдлөгийн талбайд техникийн нөхөн сэргээлт хийж дууссан талаар Газар хариуцсан байгаль орчны ажилтанд цаг тухайд нь мэдэгдэх.</li> </ul>
<b>Нийгмийн хариуцлагын хэлтэс</b>	<ul style="list-style-type: none"> <li>Техникийн нөхөн сэргээлтийнхээ явцад соёлын өвийг хамгаалах шаардлагыг газар шорооны баг эсвэл гүйцэтгэгчид биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих.</li> <li>Нөхөн сэргээлтийн хяналт шалгалтад оролцож, орон нутгийн харилцааны үүднээс нөхөн сэргээлтийн нөхцөл байдлын талаарх санал хүсэлтээ Газар хариуцсан байгаль орчны ажилтанд бичгээр гарган өгөх.</li> <li>Техникийн нөхөн сэргээлтийн нөхцөл байдлын талаарх нутгийн иргэдийн гомдлын талаар байгаль орчны хэлтэст (ялангуяа газар хариуцсан багт) мэдээлэх.</li> </ul>

## 4 ЖУРАМ

### 4.1 Техникийн нөхөн сэргээлтийн тов тогтоох нь

Явцын нөхөн сэргээлт хийлгэхийн тулд уурхайг хаах үе шатанд өргөн хүрээний нөхөн сэргээлт хийхээр хойшлуулахын оронд ашиглахаа больсон газарт техникийн нөхөн сэргээлтийг болж өгвөл шуурхай хийдэг байх ёстой. Газар хөндөх зөвшөөрөл авахад зөвшөөрөгдсөн ажлыг хийж дуусгамагцаа эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлт хийхийг шаардлага болгодог. Түүнээс гадна техникийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг жил бүр гаргах бөгөөд уг төлөвлөгөөгөөр техникийн нөхөн сэргээлтэд бэлэн, хөндөгдөх зөвшөөрөлгүй хуучин газруудыг тогтооход илүүтэй анхаардаг.

### 4.2 Техникийн нөхөн сэргээлтийг гүйцэтгэх шалгуур үзүүлэлт

Техникийн нөхөн сэргээлт хийх журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0002-М	Хувилбар: 1.1

Техникийн нөхөн сэргээлтийг амжилттай болсныг илтгэх техникийн шаардлага талбай бүрт өөр байх бөгөөд тухайн талбайн техникийн нөхөн сэргээлтийг төлөвлөх явцдаа зайлшгүй биелүүлэх бүх шаардлагыг тогтооно.

Амжилттай хийсэн техникийн нөхөн сэргээлт дараах шалгуурыг хангасан байх ёстой.

- **Талбай цэвэрхэн байх ёстой.** Техникийн ажил эхлэхээс өмнө нөхөн сэргээх талбайд үлдсэн хог хаягдал, асгарсан бодисыг цэвэрлэж, хуримтлагдсан хог хаягдлыг ОТ-ын уурхайн талбар дахь зохих хогийн цэг рүү тээвэрлэсэн байх ёстой. 15 см-ээс дээш радиустай хад чулууг нөхөн сэргээх талбайгаас зайлуулна. Биологийн нөхөн сэргээлтийн үеэр ашиглах үрслэгч машиныг эвдэрч хэмхрэхээс сэргийлэх зорилгоор энэхүү тусгай шаардлагыг тавихыг Оюу толгойн Ургамлын судалгаа, нөхөн сэргээлтийн баг санал болгосон юм.
- **Нөхөн сэргээж дууссан газрын хэлбэр байдал** байгалиараа, эргэн тойрныхоо газар нутагтай адилхан харагдах ёстой.
- **Нөхөн сэргээж дууссан налуу/хэвгий газрын өнцөг** 18 градусаас ихгүй хэвгийтэй байх ёстой. Энэ шаардлагыг хангуулахаар зах/ирмэгийн өнцөгийг эвдэх гэж байгаа бол энэ ажлаа зөвшөөрөгдсөн газрын хил хязгаар дотор л хийх ёстой.
- **Газрын тогтвортой байдал.** Нөхөн сэргээсэн газрыг ашиглах хүн, дээр нь бэлчээрлэж, нутаглах мал, зэрлэг амьтдын аюулгүй байдлыг хангах үүднээс газрын тогтвортой байдлыг нарийн няхуур авч үзнэ. Налуу хэвгий газрыг нурахаас сэргийлж карьерийн дахин хэлбэржүүлсэн зах ирмэг, түүнтэй адил төстэй хийц хийгээд овойж товойсон илүүдэл хөрстэй газарт инженерийн зураг төслийг хэрэгжүүлнэ. Ухсан газрыг буцааж булахдаа нягтралын хэмжээг нарийн мэргэжлийн инженерүүд тодорхойлон зохих нягтралтайгаар булна. Гэхдээ энэ журмын хамрах хүрээтэй уялдуулахад, ашигт малтмалын хаягдлын цэг, ил уурхайн хана, гүний уурхайн байгууламж зэргийн техникийн нөхөн сэргээлтэд уг хүчин зүйлийг авч үзэхгүй болно.
- **Элэгдэл эвдрэлийг бууруулах.** Нөхөн сэргээсэн газар нутгаас гаднах байгаль орчин доройтоход нөлөөлөх бас нэгэн хүчин зүйл болохоос сэргийлж нөхөн сэргээсэн газарт элэгдэл бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Нөхөн сэргээсэн талбай дахь элэгдлийг хянах хэрэгцээ шаардлагын талаарх инженер техникийн үнэлгээг техникийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө гаргах явцад хийх ёстой. Ерөнхийдөө налуу/хэвгий газрын өнцөг бага байх тусам урсацын хурд бага байдаг. Зах ирмэгээр (Өгсөх, уруудах налуу бус) газар самнан ховил гаргах нь хөрсний элэгдэл эвдрэлийг ихээхэн бууруулахад бас нэмэр болдог. Түүнээс гадна, байгалийн суваг шуудууны ховилыг сэргээнэ. Шаардлагатай бол нөхөн сэргээсэн газрын хаяа хязгаарт хур тунадас хураах суваг шуудуу гаргана, эсвэл боломжтой бол байгалийн ургамалжилт бүхий эргэн тойрны газар нутаг руу тунадас урсахаас сэргийлнэ. Голын эрэг ирмэг элэгдэж эвдрэхээс сэргийлэхийн тулд голын гарманд ус гаргуур суурилуулж, усны урсгалыг уг хоолой руу чиглүүлэх шаардлагатай.
- **Хур тунадасны тогтоол ус, цөөрөм** нь орон нутгийн иргэд, мал сүрэг, ан амьтдын аюулгүй байдалд хүндрэл бэрхшээл учруулдаг. Тиймээс нүхний налуу хажууг шинэчилэн хэлбэржүүлэх, ухлагын илүүдэл материалаар ухлагын ёроолыг булаах, хуримтлагдсан буюу нэмэгдсэн урсацыг зайлуулах нүх гаргах зэргээр тогтоол ус, цөөрөм бий болохоос сэргийлэх ёстой.

Техникийн нөхөн сэргээлт хийх журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0002-М	Хувилбар: 1.1

- **Өнгөн хөрсний хучилтын зузаан, боловсруулалт** нь нөхөн сэргээлт хийсний дараа байнга нэмэлт ажил хийх юмуу хогийн ургамал цэвэрлэх шаардлага бий болгохооргүй байх ёстой. Энэ шаардлагыг хэрэгжүүлэхэд “Оюу толгой”-н Ургамлын судалгаа, нөхөн сэргээлтийн баг чиг заавар өгч, шалгана.
- Ухлагыг **булахад** эхлээд зөөлөн чулуулаг материал юмуу геологийн бусад материалаар булаад, дараа нь ул хөрсөөр хучиж нягтруулдаг. Хаяалбар хийж, нягтруулсаны дараа л өнгөн хөрсийг тараах ёстой.
- Газар **самнаж** гаргасан ховил нь говийн өмнөд бүсэд хойд, баруун хойд зүгээс ирэх салхины зонхилох чиглэлтэй перпендикуляр байх ёстой. Ингэснээр чийг хуримтлуулж, салхинд туугдсан үрийг хотгор газарт барьж үлдээж болно.
- Ажил дуусмагц нөхөн сэргээсэн газар дээгүүр машин механизм явахаас сэргийлж, тус талбайг тойруулан **тэмдэг** босгосон байх ёстой. Тэмдэг салхи шуурганд хөдлөхөөргүй, монгол, англи хоёр хэлээр бичсэн, жолооч нарт тодорхой уншигдахаар бичигтэй байх шаардлагатай.

#### 4.3 Техникийн нөхөн сэргээлтэд өнгөн хөрс ашиглах нь

Өнгөн хөрсийг дахин ашиглах удирдлагад баримтлах стратегийг “Өнгөн хөрстэй ажиллах журам”-д (ОТ-10-Е14-PRC-0001) нэгд нэгэнгүй/дэлгэрэнгүй заасан бий.

Эвдэрсэн газрыг нөхөн сэргээхдаа өнгөн хөрсийг дахин ашиглахад дараах шаардлагыг биелүүлнэ. Үүнд:

- Хадгалж байсан өнгөн хөрсөө бэлдсэн/нөхөн сэргээсэн газрын гадарга дээгүүр жигд тараана. Өнгөн хөрсний зузаан нь газар хөндөж эхлэхэд хуулж авсан өнгөн хөрсний давхаргын зузаантай адил байна. Нөхөн сэргээх талбайд өнгөн хөрс бэлэн байхгүй бол өөр бэлэн эх үүсвэрээс өнгөн хөрсийг зөөх ба ингэхдээ шинээр газар хөндөж буй талбай, эсвэл өнгөн хөрсийг удаан хадгалсан овоолгоос шууд тээвэрлэн авчирна. Ямар эх үүсвэрээс өнгөн хөрсийг авахыг Ургамлын судалгаа, нөхөн сэргээлтийн баг шийднэ.
- Нөхөн сэргээлтэд ашиглах өнгөн хөрс уг газрын унаган өнгөн хөрс эсвэл адил төрлийнх байна. Унаган өнгөн хөрснийх нь чанар цагийн явцад өөрчлөгдсөн байвал дахин ашиглахын өмнө боловсруулалт хийнэ.
- Хүчтэй салхи шуурганы үеэр тээвэрлэх, ачих/буулгах, тараах ажлыг түр зогсоон тоос дэгдэхийг багасгадаг байх ёстой.

#### 4.4 Нөхөн сэргээлтэд ашиглах авто зам, түр зам

##### 4.4.1 Нөхөн сэргээлт хийх авто зам, түр замыг тодорхойлох

Нөхөн сэргээлт хийх авто зам, түр замыг тодорхойлохдоо доорх журмыг хэрэгжүүлнэ:

- Нөхөн сэргээлт хийх шаардлагатай хуучин буюу ашиглагддаггүй зам, түр замыг холбогдох оролцогч талуудтай зөвлөлдөн тодорхойлох;
- Тодорхой зам, түр зам бүрт нөхөн сэргээлтийн ажлыг эхлүүлэх зөвшөөрлийг ТУБ болон ҮАХ-ноос авна.

Техникийн нөхөн сэргээлт хийх журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0002-М	Хувилбар: 1.1

#### 4.4.2 Авто зам, түр замын нөхөн сэргээлтийн процесс

Нөхөн сэргээлт хийх зам, түр замыг тодорхойлохдоо доорх үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ:

- Зах ирмэгийг хэлбэржүүлэх, хөрсийг сийрэгжүүлэх шаардлагатай эсэхийг тодорхойлохын тулд ОТ– н Байгаль орчны хэлтэс зам, түр замын нөхцөл байдалд үнэлгээ хийнэ. Хөрсний элэгдлээс сэргийлэхийн тулд эгц налуу газар барьсан зам, түр замын гадаргууг тэгшлэхгүй. Мөн байгалийн жамаар ургамалжилт ахин явагдсан замд хүрэхгүй үлдээнэ;
- Хэрэв налуу газрыг дагаж хөрс сийрүүлсэн бол усанд идэгдэх боломжийг багасгах үүднээс замын дагуу байнгын далан хаалт барих шаардлагатай.
- Авто зам, түр замын трассыг гаргаж бэлдэх явцад замын хажуу руу түрсэн ургамлын үлдэгдэлтэй өнгөн хөрсийг тухайн авто ба түр замын уртын дагуу самнах гадаргуу дээгүүр тараана;
- Хөрсийг самнасны дараа долгиотсон гадаргуу үүсэх бөгөөд улмаар ургамлын үр хөрсөнд тогтож, усны нэвчилт сайжирна. Ингэснээр дагтаршаагүй хөрсөнд үр хурдан соёолох боломжтой болно;
- Сайжруулсан замын хөрсийг нөхөн сэргээхдээ замыг тэгшилсэн дүүргэгч материалыг эргэн тойрны гадарга руу зайлуулж, хэрэглэж болох газар руу нь (Жишээлбэл карьерийг буцаан сэргээх) зөөнө. Өнгөн хөрсийг ул хөрстэй барьцалдуулахад нэмэр болох үүднээс хатуу гадаргыг 15-20 см-ийн гүнтэй самнана. Сийрүүлсэн гадаргыг авто замын хөрсийг нөхөн сэргээхэд хэрэглэхээр хажууд нь хадгалж байсан өнгөн хөрсөөр хучиж, самнана.

#### 4.4.3 Зам болон түр замын нөхөн сэргээлтийг бүрэн гүйцэтгэх

Зам, түр замын нөхөн сэргээлтийн ажлыг дуусгасны дараа дараах удирдлагын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

- Зам, түр замын нөхөн сэргээлтийг гүйцэтгэсний дараа тээврийн хэрэгсэл явахаас сэргийлэн замын төгсгөлүүдэд зохих тэмдэглэгээнүүдийг тавьсан байна.
- Нөхөн сэргээлтийн ажлын үр дүнг үнэлэх үүднээс зам дээр нөхөн сэргээлтийн үзлэг шалгалт/хяналт шинжилгээг хийнэ.
- Нөхөн сэргээлтийн үр дүн тус ажлын шалгуур үзүүлэлтүүдийг хангахгүй байгаа гэж үзсэн бол газар шорооны ажлын баг, эсхүл гүйцэтгэгч нөхөн сэргээлтийн тайланд санал болгосон сайжруулах арга хэмжээг авна.

Урт хугацаанд ашиглах замын хөвөө, хажууг өнгөн хөрсөөр нөхөн сэргээж, хөрсний гадаргууг нь тогтвортой, элэгдэлд өртөхөөргүй болгоно.

### 4.5 Карьерын нөхөн сэргээлт

#### 4.5.1 Карьерыг нөхөн сэргээх журам

Карьерын нөхөн сэргээлтийг хийхэд дараах шаардлагуудыг дагаж мөрдөнө:

- Нөхөн сэргээх талбай нь ердийн болон барилгын хог хаягдалгүй байна. карьер ухалтын ажил дууссаны дараа үйл ажиллагаатай холбоотой үүссэн бүх материал, хог хаягдлыг төслийн талбайгаас зайлуулж, ОТ-н Хог зайлуулах байгууламжид авчирна;
- Бүх бохирдсон хөрсийг цуглуулж, ОТ-н Хөрсийг цуглуулах байгууламж руу хүргүүлнэ;

Техникийн нөхөн сэргээлт хийх журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0002-М	Хувилбар: 1.1

- Нөхөн сэргээлтийн тоног төхөөрөмжийг зөвшөөрөгдсөн замаар карьерын талбайд оруулах ёстой бөгөөд тэдгээрийн хөдөлгөөн нь эвдэрсэн газрын хүрээнд явагдана;
- Овоолсон материалыг экскаватор ашиглан карьераас гаргасны адилаар карьерт буцаан дүүргэнэ (эхлээд ул хөрсийг дараа нь өнгөн хөрсийг хийнэ). Тайлбар: Хэлбэржүүлэлт, нягтруулалтыг хийсний дараа өнгөн хөрсийг тараана;
- Эвдэрсэн карьерын талбайг дахин хэлбэржүүлж, тухайн газар нутгийг орон нутгийн ард иргэд, мал, амьтанд аюулгүй болгох;
- Газрын гадаргуугийн түвшнээс карьерын ёроол хүртэл 15-18-с ихгүй хэмийн налуу үүсгэхээр тооцож, орчны материалыг ашиглан, гадаргууг ачигч буюу бульдозероор хэлбэржүүлнэ. Карьерын захад байгаа материалыг хөндөгдөөгүй ургамлаас холдуулан карьер руу түрж оруулан захын нөлөөллийг арилгаж, 15-18 хэмийн налуу үүсгэх боловч газар хөндөхийг зөвшөөрсөн талбайн гадна газар нэмж хөндөхгүй (Газар хөндөх зөвшөөрлийн өргөдөлд заасны дагуу);
- Газрын гадарга дээр цөөрөм байгуулах нь хөрсний эвдрэл үүсгэх магадлалтай, дахин ургамалжих явцыг сааруулдаг тул цөөрөм үүсэх нөхцөлийг багасгаж, ухмал дотор хонхор үүсэхийг багасгах арга хэмжээ авна; Цөөрөм үүссэнээр мөн мал, амьтан бэртэж гэмтэх эрсдэл учруулдаг.
- Салхинд элэгдэхийг бууруулах зорилгоор хэлбэржүүлсэн гадаргууг нягтруулж, газрын хэлбэрийг тогтвортой болгоно;
- Өнгөн хөрсийг хамгийн багадаа 10 см зузаантайгаар карьерын талбай дээгүүр жигд тараана. Өнгөн хөрсний зузааныг тухайн талбайд анх байсан өнгөн хөрсний зузаантай ижил болгоно;
- Эвдрэл үүсэхээс сэргийлэхийн тулд хэлбэржүүлсэн талбайтай залгаа орших газрыг газрын налуутай нь перпендикуляр чиглэлд ховил татна. Ховилыг гүн хийх бөгөөд ингэснээр хүчтэй бороо, салхины улмаас ховил эвдрэхгүй, бат бөх байна. Грэйдерт бэхэлсэн 3-4.5 м өргөнтэй хөрс самнах ирийг 15 см хүртэл доошлуулан, буцаан дүүргэсэн суваг дээгүүр явж, сувгийн хоёр талаар 500 мм өргөнтэй хөрсийг нэмж самнана. Ингэснээр хөрсний нягтрал сайн хийгдэж, Хойд болон Баруун хойд зүгээс зонхилох салхины үндсэн чиглэлтэй перпендикуляр ховил үүсгэж, үр соёлолтыг нэмэгдүүлнэ.
- Захын нөлөөг арилгаж, үр, бордоог илүү сайн тарахад дэм болохын тулд карьерын эргэн тойронд 5 хүртэлх метрээс хөндөгдөөгүй ургамлан нөмрөгийг татна.
- Цаашдын ажилд зориулан нээлттэй үлдээх, яаралтай нөхөн сэргээлт хийх шаардлагагүй карьеруудыг тодорхойлно. Гэхдээ осол гэмтэл гарахаас сэргийлж ийм талбайг тойруулж хашаа татах шаардлагатай.

#### 4.5.2 Карьерын нөхөн сэргээлтийг бүрэн гүйцэтгэх

Карьерын нөхөн сэргээлтийг бүрэн гүйцэтгэсний дараа доорх шаардлагуудыг хангаж ажиллана.

- Нөхөн сэргээлтийг бүрэн гүйцэтгэсэн тухай Байгаль Орчны Хэлтэст нэн даруй мэдэгдэх ёстой;
- Байгаль орчны хэлтсийн Газар хариуцсан баг нь Ургамлын судалгааны баг, Нийгмийн хариуцлагын хэлтсийн төлөөлөгчидтэй хамт нөхөн сэргээгдсэн нөхцөл байдлыг үзэж шалгана;
- Хэрэв тус нөхцөл байдал байгаль орчин, орон нутгийн шаардлага хангахгүй байвал газар шорооны баг, эсхүл гүйцэтгэгч нөхөн сэргээлтийн тайланд санал болгосон сайжруулах арга хэмжээг авна;
- Амжилттай нөхөн сэргээсэн талбайн талаар ЭМААБО-ы Хууль дүрмийн хэрэгжилтийн багт мэдэгдэж, улсын комиссын үзлэгийг зохион байгуулуулах бөгөөд

<b>Техникийн нөхөн сэргээлт хийх журам</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0002-М	Хувилбар: 1.1

- улсын комисс MSN 5917:2008 болон MNS 5918:2008 стандартуудад заасан нөхөн сэргээлтийн шаардлагууд биелсэн эсэхийг тогтооно;
- Нөхөн сэргээсэн карьерийг орон нутгийн засаг захиргаанд хүлээлгэн өгнө;
  - Тухайн карьерийн газрыг хөндөх зөвшөөрлийг орон нутгийн засаг захиргааны гаргасан нөхөн сэргээсэн актад үндэслэн хүчингүй болгоно.

## 4.6 Геологийн хайгуулын цооногийн нөхөн сэргээлт

### 4.6.1 Геологийн хайгуулын цооногийн нөхөн сэргээлтийн тухай журам

Геологийн хайгуулын цооногийн нөхөн сэргээлтийг хийхэд доорх журмыг хэрэгжүүлнэ:

- GPS-р өрөмдсөн цооногийн байршлыг тодорхойлох, цооногийн ирмэг орчмыг цэвэрлэн цооногийг PVC хоолой суурилуухад бэлтгэх, 40 см гүн нүх ухах
- 2 эсхүл 3 м PVC хоолойн 50 см-ийг гадаргуу дээр ил үлдээн цооногоор доош буулгана. Үүнтэй зэрэгцүүлэн PVC хоолойг тогтвортой байлгахын тулд 50 см модон гадас хадна;
- Цемент, элс, хайргыг 30x50x20-ийн хаьрцаатайгаар хольж, шавар бэлтгэнэ. Цементийг цутгахын өмнө 60x60 см хэвийг PVC хоолойг тойруулан тавина. Хэвэнд 7-8 см цемент цутгаж, 4x4см нүхтэй, 40x10 см хэмжээтэй төмөр тор хийнэ. Энэ нь цементийг хагарахаас хамгаалж, бэхжүүлнэ. Дараа нь цементийг хэвний ирмэгтэй тэнцүүлэн цутгана. Хэвний өндөр нь ойролцоогоор 15 см байна;
- Цемент хатуурахаас өмнө цооногийн дугаарыг 10 мм хэмжээтэй хайргаар нүдэнд харагдахуйц шигтгэнэ;
- Хөнгөн цагаан төмөр дээр цооногийн дугаарыг бичиж, PVC-ийн дээд ирмэгт нүхлэн тогтооно.

### 4.6.2 Цооногийн нөхөн сэргээлтийг бүрэн гүйцэтгэх

Цооногийн нөхөн сэргээлтийн дараа ажлын талбайгаас хүн хүч, тоног төхөөрөмжийг буцаан татахын өмнө Геологи судалгааны хэлтэс доорх ажлуудыг гүйцэтгэн талбайг аюулгүй, хүлээн авахуйц нөхцөл байдалд үлдээнэ:

- Цооног орчмын талбайг цэвэрлэж, хог хаягдлыг зайлуулна;
- Тагласан цооногийг фото зургаар баримтжуулан, бүртгэнэ;
- Хучилтын тухай дэлгэрэнгүй мэдээлэл, зургийг мэдээллийн санд оруулна.
- Нөхөн сэргээлтийг хийж дууссан талаар Байгаль орчны хэлтэст мэдэгдэнэ;
- Хэрэв нөхцөл байдал байгаль орчин, орон нутгийн шаардлага хангахгүй байвал газар шорооны баг, эсхүл гүйцэтгэгч нөхөн сэргээлтийн тайланд санал болгосон сайжруулах арга хэмжээг авна;
- Тухайн өрөмдлөгийн талбайн газрыг хөндөх зөвшөөрлийг нөхөн сэргээлтэд хийсэн үзлэгийн тайланг үндэслэн дуусгавар хүчингүй болгоно.

### 4.6.3 Ажлын талбайгаас буцаан татахын өмнө төслийн талбайг цэвэрлэх

Тоног төхөөрөмж, аюултай материалыг ажлыг бүрэн дуусгасан талбайгаас холдуулах, нөхөн сэргээлт хийхийн өмнө ил уурхай болон бусад аюултай газарт гаднаас нэвтрэхээс хамгаалсан байх ёстой.



Техникийн нөхөн сэргээлт хийх журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0002-М	Хувилбар: 1.1

**Дэлгэрэнгүй журмыг А хавсралтаас харна уу!****4.7 Барилгын талбайн техникийн нөхөн сэргээлт**

Барилгын талбайн газар хөндөх зорилго (шугам хоолой суурилуулах, онгоцны буудал, албан байр, түр суурин гэх мэт), цар хүрээ өөр өөр байдаг. Үр дүнтэй төлөвлөхөд нь зориулж хариуцсан багт нь тухайн талбайд зориулсан нөхөн сэргээлтийн удирдамжийг өгдөг. Техникийн нөхөн сэргээлтийг амжилттай болгох бүх зайлшгүй шаардлагыг удирдамжид тусгадаг. Ерөнхийдөө барилгын талбайн техникийн нөхөн сэргээлт хийхдээ дараах шаардлагуудыг биелүүлэх ёстой.

- Эргэн тойрны хашаанаас бусад барилга, хаалт гэх мэт бүх босоо байгууламжийг буулгана. Мал амьтан, нутгийн иргэдийг онгорхой нүх, гуу жалга, уурхайн нүхнээс хол байлгах, нөхөн сэргээх талбайд ажиллаж буй хүнд машин механизмтай зам огтлолцох, мөргүүлэхээс сэргийлэхийн тулд хашаалсан газрыг нөхөн сэргээсний дараа гаднах хашааг буулгаж авна.
- Бетон суурийг зайлуулна.
- Кабель утас, бохирын танк/сав, шугам хоолой, хоолой гэх мэт газар доорх бүтээцүүдийг авна.
- Үлдэгдэл хог хаягдал, хог, бетоны үлдэгдлийг талбайгаас цэвэрлэнэ.
- Талбайгаас авч холдуулсан бүх материалыг Оюу толгойн хог хаягдлын удирдлагын журмын дагуу хаяна. Ус хангамжийн дэд бүтцийн баг хаях арга, газрыг зааж зөвлөнө.
- Бохир усны байгууламжуудыг нөхөн сэргээх ажлын хүрээнд төмрийн хог хаягдал хаях цэгт хаяхаар ОТ-н цогцолбор руу тээвэрлэхээс өмнө бохирын танк/савыг хоосолж, ариутгана. Бохирын танк/савыг нь авсан ухлагыг/нүхийг ухлагаас гарсан ул хөрсөөр буцааж булахын өмнө ариутгах ёстой. Суулт үүсгэхгүйн тулд буцааж булсан газрыг сайтар нягтруулна.
- Хайрган бүрхэвчийг/давхаргыг нөхөн сэргээх гадаргаас зайлуулах хэрэгтэй бөгөөд ууршуулах цөөрөм, бохирын танк/сав, эргэн тойрны гуу жалгыг буцаан булахад ашиглаж болно. Оюу толгойн Ургамлын судалгааны баг биологийн нөхөн сэргээлтийн үеэр ашиглах үрлэгч машиныг эвдэрч хэмхрэхээс сэргийлэх зорилгоор 15 см-ээс дээш радиустай хад чулууг нөхөн сэргээх бүх газраас зайлуулна.
- Хөрс шорооны аливаа илүүдэл овоолгыг нөхөн сэргээлтийн талбайгаас зөөж холдуулах ёстой бөгөөд тухайн нөхөн сэргээлтийн талбай, эсхүл бусад газар дахь гуу жалга, нүх зэргийг буцаан булахад ашиглаж болно.
- Газар доорх бүтээцийг нь ухаж авсан газрыг буцааж булахдаа эхлээд гүнээс гаргасан материалыг хийж, дараа нь ул хөрс, эцэст нь өнгөн хөрсөөр дээрээс нь хучих байдлаар дарааллаар нь булна. Өнгөн хөрсөөр хучихаас өмнө тухайн газрыг нягтруулна.
- Хашаалсан газрыг тэгш (эсвэл эргэн тойрных нь газар нутагтай адилхан болгосон), цэвэрхэн болгосоны дараа ул ба өнгөн хөрсийг хангалттай барьцалдуулахын тулд бүх гадаргыг 30 см-ийн гүнтэй сийрүүлнэ. Энэ шаардлагыг үл биелүүлбэл өнгөн хөрсөн бүрхэвч салхинд идэгдэхээс гадна тийм гадаргад биологийн нөхөн сэргээлт зэрэг дахин ургамалжилт хийхэд амжилттай болохгүй.

Техникийн нөхөн сэргээлт хийх журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0002-М	Хувилбар: 1.1

- Бэлтгэсэн гадаргыг Ургамлын судалгаа, нөхөн сэргээлтийн багийн заасан зузаантай өнгөн хөрсөөр хучна.
- Өнгөн хөрсөөр хучсан гадаргыг Хойд буюу Баруун хойд талтай перпендикуляр чиглэлээр самнана.

#### 4.8 Техникийн нөхөн сэргээлтийг үзэж шалгах нь

Батлагдсан газар хөндөх зөвшөөрөлд нөхөн сэргээлт хийх шаардлагыг хураангуйлан тусгасан байдаг бөгөөд тэдгээрийн хэрэгжилтийг Байгаль орчны хэлтсийн Газрын болон Ургамлын судалгаа, нөхөн сэргээлтийн баг хамтран газар хөндөх зөвшөөрлийг хаах үзлэгээр шалгана. Газар хөндөх зөвшөөрөлгүй газруудын хувьд, Байгаль орчны хэлтсийн Газар хариуцсан баг нөхөн сэргээх ажил эхлэхээс өмнө техникийн нөхөн сэргээлтийг үр дүнтэй хийх удирдамжийг Төслийг зохицуулах баг, Гүйцэтгэгчид өгнө. Нөхөн сэргээх талбайд очиж үзсэний үр дүнд техникийн нөхөн сэргээлтийн ажлын цар хүрээг тогтоож, Төслийг зохицуулах баг, Гүйцэтгэгдээр мөрдүүлэхээр дэлгэрэнгүй баримт бичгээр боловсруулан өгнө.

Техникийн нөхөн сэргээлтийн үзлэг шалгалтыг дараах үе шатуудаар хийнэ. Үүнд:

- Техникийн нөхөн сэргээлт дууссан талаар Төслийг зохицуулах багууд Байгаль орчны хэлтсийн Газар хариуцсан багт мэдэгдэх.
- Байгаль орчны хэлтсийн Газар хариуцсан баг техникийн нөхөн сэргээлтийн үзлэгийн товыг тогтооно.
- Байгаль орчны хэлтсийн Газрын болон Ургамлын судалгааны баг хамтран техникийн нөхөн сэргээлтийн үзлэг шалгалтыг хийнэ.
- Ургамлын судалгаа, нөхөн сэргээлтийн баг өнгөн хөрсөн бүрхэвч, хад чулууг зайлуулах шаардлагуудын хэрэгжилтийг шалгаж, нөхөн сэргээсэн газрын нөхцөл биологийн нөхөн сэргээлт хийхэд тохиромжтой эсэх талаар тайлбар дүгнэлт гаргана.
- Байгаль орчны хэлтсийн Газар хариуцсан баг тодорхой талбайн техникийн нөхөн сэргээлтийн ажлын хамрах хүрээнд тусгасан бүх шаардлагын биелэлтийг шалгаж, газар хөндөх зөвшөөрлийг хаах үзлэг шалгалтын тайлангийн маягтад (В хавсралт) сайжруулах зөвлөмж бүхий тайлан, эсхүл нөхөн сэргээсэн талбайг хүлээн авсан талаарх дүгнэлтээ бэлтгэнэ.
- Түрээсийн талбайд үл багтах газарт техникийн нөхөн сэргээлт амжилттай хийж дууссан талаарх тайланг ЭМААБО-ы багт шилжүүлэн тус талбайг орон нутгийн засаг захиргаанд хүлээлгэн өгөхөд бэлэн болохыг мэдэгдэнэ.
- ЭМААБО-ы Хууль дүрмийн хэрэгжилтийн баг техникийн нөхөн сэргээлт хийх, түрээсийн талбайгаас гадуурх талбайнуудад улсын комиссын үзлэг шалгалтыг зохион байгуулна.
- Орон нутгийн засаг захиргаа нөхөн сэргээсэн акт бичиж өгснөөр тухайн газрыг ОТ хариуцахаа больсоныг бататгаж байгаа боловч ОТ тухайн газрын биологийн нөхөн сэргээлтийг дуусгах ажлыг хариуцсан хэвээр байна.
- Техникийн нөхөн сэргээлтийг амжилттай хийсэн газруудыг ОТ-ын гео-мэдээллийн санд бүртгэнэ.

Техникийн нөхөн сэргээлт хийх журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0002-М	Хувилбар: 1.1

## 5 НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ, ТОВЧИЛСОН ҮГС

**Карьер:** Өөр газар ашиглах зорилгоор материал (ихэвчлэн хөрс, хайрга, элс) ухаж авсан газар

**ГЗБТС:** Газар зүйн байршил тогтоох систем

**ТУБ:** Төслийн удирдлагын баг

**ГХЗ:** Газар хөндөх зөвшөөрөл

**Нөхөн сэргээлт:** Эвдэрсэн газрыг хүрээлэн буй орчинд нь нийцүүлэн тогтворжуулж, цаашид өөрөө нөхөн сэргэхүйц байдалд оруулах арга хэмжээ, үйл ажиллагаа.

**Өнгөн хөрс:** Ерөнхийдөө хөрсний ("А" хүрээ) дээд давхаргад хамаарах хязгаарлагдмал нөөц, биологийн хувьд идэвхтэй амьд нэгдлүүд бөгөөд энэ нь ургамлын ургалт болон шинэ газар бүрэлдэн тогтоход нэн чухал. Өнгөн хөрс нь байгалийн ургамлын нөөц, үндэс, бичил организм, органик нэгдлүүд болон тэжээллэг чанар өндөртэй нэгдлүүдийг агуулдаг. Зам гаргах, газар ухах зэргийн улмаас өнгөн хөрс амархан эвдэгддэг.

## 6 АШИГЛАСАН МАТЕРИАЛ, ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧИГ

- MNS 5914:2008 Байгаль орчин. Нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт
- MNS 5917:2008 Байгаль орчин. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлагууд
- Газрын хэвлийн тухай хууль. Газрын хэвлийн тухай хууль, 20.2.4-р зүйл
- Газар хөндөхөд тавих хяналт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө (ОТ-10-Е14-PLN-0001)
- Уурхайг хаах төлөвлөгөө (ОТ-10-Е14-PLN-0002)
- Агаар мандал руу хорт бодис ялгарах асуудлыг удирдан зохицуулах төлөвлөгөө (ОТ-10-Е14-PLN-0001)
- Хор аюултай материал, эрдсийн бус хаягдлын удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е15-PLN-0001)
- Газар хөндөх зөвшөөрлийн журам (ОТ-10-Е14-PRC-0003)
- Өнгөн хөрстэй ажиллах журам (ОТ-10-Е14-PRC-0001)
- Биологийн нөхөн сэргээлт хийх журам (ОТ-10-Е14-PRC-0010)
- Дурсгалт зүйл олдсон тохиолдолд баримтлах журам (Лавлах дугаар байхгүй)

**ОЮУ ТОЛГОЙ ХХК**

<b>Техникийн нөхөн сэргээлт хийх журам</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0002-М	Хувилбар: 1.1

**7 БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ**

Бичиг баримтын нэр	ОТ-10-Е9-PRC-0002-М ОТ-н Техникийн нөхөн сэргээлт хийх журам
Тодорхойлолт	Энэ журмын зорилго нь авто зам, түр зам, карьер, өрөмдлөгийн нүх, барилга угсралтын талбайн нөхөн сэргээлтийн ажлыг удирдамжаар хангахад оршино.
Эх зохиогч(д)	Зам, түр замын нөхөн сэргээлтийн журам: Лувсангийн Цэцэгсүрэн Карьерын нөхөн сэргээлтийн журам (BPRP): Лувсангийн Цэцэгсүрэн Цооногийг таглах, нөхөн сэргээх (DHCR): Дамдиймаагийн нЭнхбаяр
Боловсруулсан огноо	RTRP: 2010.10.30 BPRP: 2010.12.02 DHCR: 2011.12.10
Баталсан	RTRP: Шей Онилл, Байгаль орчны хэлтсийн зөвлөх
Баталсан огноо	2013.05.06
Өөрчлөлтийн тэмдэглэлийн дугаар	##

Эрсдлийн зэрэг	Үнэлгээ хийсэн огноо	Эрсдэлийг үнэлэгч	Хянан засвар хийх хуваарь	Дараагийн хянан засвар хийх хугацаа
Дунд	2013.05.06	Баасансүрэн Долгор	2 жил тутам	2017.09.02

Хувилбар	Хянан засварласан огноо	Зохиогчид	Баталсан	Хянан засварын тэмдэглэл
1.0	2013.05.06	Лувсангийн Цэцэгсүрэн, Д. Энхбаяр	Шей Онилл	Зам, түр зам, карьер болон цооногийн нөхөн сэргээлтийн баримт бичгүүдийг нэгтгэн ОТ-н нөхөн сэргээлтийн журамд тусгасан болно. Батлагдсан хувилбар
1.1	2015.09.02	Лувсангийн Цэцэгсүрэн,	Деннис Хосак	Энэ журмын цар хүрээтэй уялдуулан журмын нэрийг засварлав; “Оюу толгой”-н нөхөн сэргээлтийн удирдлагын өнөөгийн үйл ажиллагаатай албан тушаал, үүрэг хариуцлагыг нийцүүлэв; Ашигласан материал, холбогдох баримт бичгүүдийн нэрсийг шинэчлэв; Зайлшгүй шаардлага, үе шатуудыг нэмж оруулав; Биологийн нөхөн сэргээлттэй холбогдох тул хогийн ургамлын асуудлыг зохицуулах хэсэг, тавих шаардлагуудыг хасав; Хугацаа тогтоох, гүйцэтгэх шалгуур үзүүлэх, өнгөн хөрсийг дахин ашиглах, үзлэг шалгалт хийх болон барилгын талбайн техникийн нөхөн сэргээлтийн шаардлагын талаарх шинэ хэсгүүдийг нэмэв.

Техникийн нөхөн сэргээлт хийх журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0002-М	Хувилбар: 1.1

**ХАВСРАЛТ А: ЦООНОГИЙГ ТАГЛАХ БОЛОН НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙХ ЖУРАМ / ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН АЛХМУУД**

Ажлын алхмууд #	ХИЙГДЭХ АЖЛЫН ТАЙЛБАР (Ажлыг гүйцэтгэх үе шатуудын жагсаалт)	БОЛЗОШГҮЙ АЮУЛ (Байгаль орчин, аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд)	АЮУЛЫН УДИРДЛАГА (Аюулыг хэрхэн удирдан зохицуулах)
<b>1-Р ҮЕ ШАТ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ, БАГАЖ ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ҮЗЛЭГ</b>			
1	Тээврийн хэрэгслийн ашиглалтын өмнөх үзлэг	<ul style="list-style-type: none"> <li>▪ Тос, тосолгооны материал, асгарах</li> <li>▪ Гидравликийн болон тоормозны шингэн асгарах</li> <li>▪ Тээврийн хэрэгслийн бусад эвдрэл гэмтэл</li> <li>▪ Аюулгүй ажиллагааны багаж хэрэгсэл ажиллахгүй байх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Ашиглалтын өмнөх үзлэгийн картын дагуу тээврийн хэрэгсэл бүрд ашиглалтын өмнөх үзлэг хийж, ажилуулахын өмнө асуудал илэрсэн тохиолдолд засвар үйлчилгээг хийх</li> <li>▪ GEN008 журмыг уншиж, танилцах</li> </ul>
2	Эвдэрхий, бүрэн бус багаж хэрэгслийг шалгах	<ul style="list-style-type: none"> <li>▪ Төслийн талбайн гадна тоног төхөөрөмж эвдрэх (дугуй хагарах г.м.)</li> <li>▪ Ил задгай талбайд төөрөх (GPS-ын эвдрэл, доголдлыг шалгах)</li> <li>▪ Ажлын байранд эвдэрсэн болон тохирохгүй багаж хэрэгсэлтэй ажилласны улмаас гэмтэж, бэртэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Өдөр бүр ашиглалтын өмнөх бүртгэлийн картын дагуу бүх багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжид ашиглалтын өмнөх үзлэг хийж хэвших, ажиллуулж эхлэхийн өмнө асуудал үүсвэл засвар үйлчилгээг хийх</li> <li>▪ GPS-ийн ажиллагааг шалгаж, зай болон дагалдах хэрэгслийг хангалттай хэмжээгээр бэлтгэх</li> </ul>

Техникийн нөхөн сэргээлт хийх журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PRC-0002-М	Хувилбар: 1.1

2-р ҮЕ ШАТ АЧИХ, БУУЛГАХ, ТЭЭВЭРЛЭХ, ХАДГАЛАХ			
3	Элс, цемент болон бусад түүхий эдийг ачих, буулгах	<ul style="list-style-type: none"> <li>▪ Цемент асгарсны улмаас байгаль орчинд хог хаягдал үүсгэнэ</li> <li>▪ Цемент болон тоос шороо амьсгалын эрхтэнд нөлөөлж болзошгүй</li> <li>▪ Цемент болон тоос шороо нүдэнд орж цочроох</li> <li>▪ Арьсны үрэвсэл үүсгэх</li> <li>▪ Хүнд ачаа өргөсний улмаас нуруу өвдөх, нуруунд гэмтэл авах</li> <li>▪ Хэтрүүлэн ачаалснаас тээврийн хэрэгсэлд эвдрэл үүсэж болзошгүй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Ажлыг эхлүүлэхийн өмнө Портланд цементийн ХАЛМ-тай танилцах</li> <li>▪ ХАЛМ-ын Анхны тусламжийн дагуу ажиллах</li> <li>▪ ХХХ өмсөх</li> <li>▪ Тоосноос хамгаалах хэрэгсэл ашиглах</li> <li>▪ Хамгаалалтын шил, гутал, бээлий</li> <li>▪ Цемент, элсний уутыг сайтар битүүмжлэх, хэтрүүлэн ачаалах, хурц өнцөгтэй зүйлд ойр тавихгүй байх</li> <li>▪ Төслийн талбайн аюулгүй ажиллагааны стандарт, журмын дагуу хүнд зүйлсийг ачиж, буулгах Тээврийн хэрэгсэлд багтаамжийн дагуу ¼ тонн ачаа ачих</li> <li>▪ Цементийг уснаас хол тавих</li> </ul>
4	Ажлын талбай руу ирэх, буцахдаа аюулгүй жолоодох	<ul style="list-style-type: none"> <li>▪ Жолоо барьж яваад осол гаргах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>▪ GEN008 журмыг дагаж мөрдөх</li> </ul>
5	Цемент хадгалах	<ul style="list-style-type: none"> <li>▪ Харшил үүсгэх, нүдэнд орох, амьсгалын эрхтэнд нөлөөлөх, байгаль орчинд хог тарих</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Хүчил, чийгнээс хол хадгалах, төмөр хайрцаг, цаасан уутыг сайтар битүүмжлэх</li> <li>▪ Асгарсан тохиолдолд тоос шороо босголгүйгээр хүрзээр болгоомжтой цуглуулж авна</li> </ul>
3-р ҮЕ ШАТ ЦООНОГ УХАХ, БЭЛТГЭХ			
6	GPS-р өрөмдсөн цооногийн байршлыг тодорхойлох, цооногийн ирмэг орчмыг цэвэрлэн цооногийг PVC хоолой суурилуухад бэлтгэх, 40 см гүн нүх ухах	<ul style="list-style-type: none"> <li>▪ Цооног ухах явцад ямар ч осол зөрчил тохиолдож болно (гар хөлөө лоомонд цохиулах)</li> <li>▪ Гар ажиллагаатай холбоотой гэмтэл бэртэл</li> <li>▪ Багажийг цооногт унагах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>▪ ХХХ өмсөх</li> <li>▪ Тоос нэвтрүүлэхгүй, тоосноос хамгаалах маск болон шил зүүх</li> <li>▪ Хамгаалалтын гутал</li> <li>▪ Цооног ухаж буй ажилчны анхаарлыг сарниулахгүй байх, багаж хэрэгсэлтэй болгоомжтой ажиллах</li> </ul>
4-р ҮЕ ШАТ PVC ХООЛОЙГ БАЙРЛУУЛЖ/СУУРИЛУУЛЖ, ЦЕМЕНТИЙН ШАВРААР ТОГТООХ			
7	2 эсхүл 3 м PVC хоолойн 50 см-ийг гадаргуу дээр ил үлдээн цооногоор доош буулгана. Үүнтэй зэрэгцүүлэн PVC хоолойг тогтвортой байлгахын тулд 50 см модон гадас хадна	<ul style="list-style-type: none"> <li>▪ PVC хоолойг цооногоор доош буулгах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Нэг хүнээр PVC хоолойг бариулах</li> </ul>

Техникийн нөхөн сэргээлт хийх журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E14-PRC-0002-M	Хувилбар: 1.1

8	Цемент, элс, хайргыг 30х50х20-ийн хайрцаатайгаар хольж, шавар бэлтгэнэ. Цементийг цутгахын өмнө 60х60 см хэвийг PVC хоолойг тойруулан тавина. Хэвэнд 7-8 см цемент цутгаж, 4х4см нүхтэй, 40х10 см хэмжээтэй төмөр тор хийнэ. Энэ нь цеменийг хагарахаас хамгаалж, бэхжүүлнэ. Дараа нь цементийг хэвний ирмэгтэй тэнцүүлэн цутгана. Хэвний өндөр нь ойролцоогоор 15 см байна	<ul style="list-style-type: none"> <li>▪ Цемент холихтой холбоотойгоор үүсэж болзошгүй эрсдэлүүд:</li> <li>▪ харшил</li> <li>▪ нүдэнд орох</li> <li>▪ амьсгалын эрхтэнд нөлөөлөх</li> <li>▪ байгаль орчинд хог тарих</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Шаврыг 2/3 тонн хэмжээтэй шаврын хөнөгт зуурна</li> <li>▪ Салхины чиглэлийг ажиглан шаврыг зуурна.</li> <li>▪ ХХХ өмсөх</li> <li>▪ Хамгаалалтын гутал, шил, маск</li> </ul>
<b>5-р ҮЕ ШАТ ТАЛБАЙГ ДУГААРЛАХ, ХАЯГЛАХ, ЦЭВЭРЛЭХ</b>			
9	Цемент хатуурахаас өмнө цооногийн дугаарыг 10 мм хэмжээтэй хайргаар нүдэнд харагдахуйц шигтгэнэ;	<ul style="list-style-type: none"> <li>▪ Цементэнд хүрснээр арьсанд цочрол өгөх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Бээлий өмсөх</li> </ul>
10	Хөнгөн цагаан төмөр дээр цооногийн дугаарыг бичиж, PVC-ийн дээд ирмэгт нүхлэн тогтооно	<ul style="list-style-type: none"> <li>▪ Тавладаг хадаас нүд рүү үсрэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>▪ ХХХ өмсөх</li> <li>▪ Хамгаалалтын шил</li> <li>▪ Хамгаалалтын гутал</li> <li>▪ Хамгаалалтын бээлий</li> </ul>
11	Цооног орчмын талбайг цэвэрлэж, хогийг зайлуулах	<ul style="list-style-type: none"> <li>▪ Хальтирах, гулсах</li> <li>▪ Хуруу, гараа зүсэх</li> <li>▪ Хог цэвэрлэх явцад тоос, шороо нүдэнд орж болзошгүй</li> <li>▪ Хог цэвэрлэх явцад хог хаягдал салхинд хийсэн тархаж болзошгүй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Цэвэрлэж буй талбайг ажиглах</li> <li>▪ ХХХ өмсөх</li> <li>▪ Хамгаалалтын шил</li> <li>▪ Хамгаалалтын гутал</li> <li>▪ Хамгаалалтын бээлий</li> <li>▪ Хогийг уутанд хийж, амыг нь уях</li> </ul>
<b>6-р ҮЕ ШАТ. ЗУРГИЙН ПРОТОКОЛ БОЛОН МЭДЭЭЛЛИЙН САН ҮҮСГЭХ</b>			
12	Тагласан цооногийн зургийг авч, бүртгэх.	хамаарахгүй	хамаарахгүй
13	Хучилт хийсэн тухай дэлгэрэнгүй мэдээлэл болон зургийг мэдээллийн санд оруулах.	хамаарахгүй	хамаарахгүй

Техникийн нөхөн сэргээлт хийх журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2016.04.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E14-PRC-0002-M	Хувилбар: 1.1

**ХАВСРАЛТ В. ГАЗАХ ХӨНДӨХ ЗӨВШӨӨРЛИЙН ХААХ ШАЛГАЛТЫН МАЯГТ**



ГАЗАР ХӨНДӨХ ЗӨВШӨӨРЛИЙГ ХААХ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН  
LAND DISTURBANCE PERMIT COMPLETION INSPECTION REPORT

PROJECT NAME			
LDP NUMBER		AUDIT DATE	
AUDIT No.	AUDITORS		

1. Background information on the rehabilitation site					
[Insert note]					
2. Implementation of technical rehabilitation requirements (Land team)					
	Requirement	Yes	No	NA	Notes and Actions required
1.1	Site is clean and tidy				
1.2	Final land form is natural & safe				
1.3	Final slope angles less than 18 degrees gradient				
1.4	Land stability requirements implemented				
1.5	Erosion mitigation measures implemented				
1.6	Ponding potential prevented				
1.7	Topsoil cover to specified depth and adequate				
1.8	Scarification in correct direction and adequate				
1.9	Rehabilitation site signs posted				
1.10	Site-specific additional requirements implemented: a). b). c).				
3. Sign-off on topsoil cover and rocks removal condition (Flora Research and Rehabilitation team)					
[Insert comment]					
Commented by:		Signature:		Date:	
4. Audit conclusion					

REPORTED BY: Signature / Insert name /  
Signature / Insert name /

REPORT DATE:

[provide inspection photos on next pages]